



СОЁМБОМ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

МЭЭДЭЭ

127 /127/

2021.09.03

МЭНДЧИЛГЭЭ



Эрхэм генерал, офицер, ахлагч, түрүүч, байлдагч, ажилтан албан хаагч Та бүхэнд болон улс орныхоо бүтээн байгуулалтын их үйлсэд хөдөлмөр зүтгэл, залуу насаа

зориулсан үе үеийн ахмадууддаа Монгол Улсад Барилгын салбар үүсэж хөгжсөний 95, орчин цагийн Зэвсэгт хүчинд Барилгын цэрэг үүсэн байгуулагдсаны 85 жилийн ойн

баярын мэндийг өргөн дэвшүүлье.

Бүх цэргийн жанжин, маршал Г.Дэмидийн 1936 оны 3 дугаар сарын 2-ны өдрийн тушаалаар Монголын Ардын Хувьсгалт Цэргийн бүтцэд Барилгын тусгай суманг байгуулснаар өнөөгийн Барилгын цэргийн түүхийн хуудас нээгдсэн билээ.

Барилгын цэрэг нь бүтээн байгуулалтын түүхэн он жилүүдэд монгол орныг аж үйлдвэрийн орон болгох төр, засгийн бодлогын хүрээнд хүн ам цөөн суурьшсан, алслагдсан газар тариалангийн бүс нутгуудад олон арван сум, сангийн аж ахуйг байгуулж, хэдэн мянгаар тоологдох газар тариалан, мал аж ахуйн объект, 400 орчим үйлдвэрийн барилга, байгууламжуудыг бие даан барьснаар эх орныхоо хөгжил дэвшилд жинтэй хувь нэмэр оруулсан юм. Тэрчлэн нийслэл хотноо олон арван орд харш, төр, захиргааны барилгуудыг барихын зэрэгцээ Дархан, Эрдэнэт, Чойбалсан, Сүхбаатар, Булган болон бусад хот, сууринд сургууль, цэцэрлэг, эмнэлэг, соёлын төв, спортын ордон зэрэг томоохон барилгуудыг

сүндэрлүүлсний зэрэгцээ улс орны батлан хамгаалах хүч чадлын үндэс болсон материаллаг баазыг өргөтгөх чиглэлээр томоохон ажлуудыг гүйцэтгэснийг баярын энэ өдөр онцлон тэмдэглэж байна.

Зэвсэгт хүчний бүтцэд Барилга-инженерийн цэрэг байх тухай заалт Улсын Их Хурлаар ёсчлон батлагдаж, Зэвсэгт хүчний Барилга-инженерийн анги, салбарууд шинээр байгуулагдсанаар Ардын Армийн түүхэнд бие даасан томоохон салбар болтлоо хөгжсөн Барилгын цэргийн үйл ажиллагаа эрчимтэй сэргэн, улс орны өнөөгийн хөгжил дэвшил, их бүтээн байгуулалтад манлайлан оролцож байгаа нь бидний зүй ёсны бахархал юм.

Барилгын цэргийн бахархах үйлсийг бүтээж, бахдам түүхийг нь бичилцсэн үе үеийн ахмадууд болон тэдний бүтээлч үйл хэргийг түүчээлэн залгамжлагч Зэвсэгт хүчний Барилга-инженерийн цэргийн бие бүрэлдэхүүнд дахин баярын мэндчилгээ дэвшүүлж, ажил үйлсэд тань арвин их амжилт, аз жаргал, эрүүл энх, сайн сайхан бүхнийг бэлгэдэн өрөөе.

МОНГОЛ ЦЭРГИЙН СҮР ХҮЧ, СҮЛД ХИЙМОРЬ МӨНХӨД МАНДАН БАДРАХ БОЛТУГАЙ!
ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЖАНЖИН ШТАБЫН ДАРГА ДЭСЛЭГЧ ГЕНЕРАЛ Д.ГАНЗОРИГ

АРДЫН АРМИЙН 019 ДҮГЭЭР АНГИЙН БАЙЛДААНЫ ТУГИЙГ 016 ДУГААР НЭГТГЭЛД ГАРДУУЛАН ӨГӨВ



Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэл

Батлан хамгаалахын сайдын 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн тушаалаар Байлдааны гавьяаны улаан тугийн одонт Жанжин Д.Сүхбаатарын нэрэмжит Ардын Армийн 019 дүгээр ангийн нэрэмжит нэр, туг, одон, түүхийн тус бүрийн хуулбарыг Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлийн артиллерийн холимог дивизионд өвлүүлэн шилжүүлсэн юм.

Түүнчлэн Ардын Армийн 019 дүгээр ангийн байлдааны тугийг

тус дивизионд хүлээлгэн өгөх арга хэмжээ зохион байгуулагдлаа. Тус ёслолын арга хэмжээнд Хуурай замын цэргийн командлагч, хошууч генерал Б.Амгаланбаатар, бэлтгэл хошууч генерал Ч.Цэрэндагва болон Ардын Армийн 019 дүгээр ангийг удирдаж байсан үе үеийн удирдлага, ахмад дайчид оролцлоо. Үйл ажиллагааны хүрээнд Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлийн артиллерийн холимог дивизионд тус ангийн түүхийг харуулсан дайчин алдрын танхимыг шинээр тохижуулан байгуулсан юм.

Хошууч Д.ДОЛГОРЖАВ



МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН 222,346 +3805	ЭДГЭРСЭН 199,876 +2570	НАС БАРСАН 948 +4
-----------------------------------	---------------------------	----------------------

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН 4647 +82	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БҮЙ 173 +18	ЭДГЭРСЭН 4384 +18
-----------------------------	--------------------------------	----------------------

БАТЛАН ХАМГААЛАХ ҮЗЛЭГ ШАЛГАЛТЫГ ОРОН НУТАГТ ҮРГЭЛЖЛҮҮЛЭН ЗОХИОН ЯВУУЛЖ БАЙНА



Дорноговь аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб

Аймгийн Засаг даргын 2021 оны "Батлан хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах зорилгоор орон нутагт үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллага, иргэдэд шалган туслах ажлыг явуулах" тухай А/330 дугаар захирамж гарган ажиллаж байна.

Захирамжид аймгийн 14 сумын 196 байгууллагын 18-50 насны нийт 3400 орчим албан хаагч, иргэд хамрагдахаар тусгагдсан бөгөөд тус шалган туслах ажилд одоогийн байдлаар 4 сумын 48 байгууллагын 1326 албан хаагч, иргэд хамрагдаад байна.

Захирамжид тусгагдсан иргэдийн 39 хувь нь шалгалтад хамрагдсанаас цэргийн бүртгэлийн журам зөрчсөн, цэргийн үүрэгтний үнэмлэхэд тэмдэглэл дутуу хөтлөгдсөн, иргэний шилжилт хөдөлгөөн хийгдээгүй, цэргийн жинхэнэ албаны татлагаас зайлсхийсэн зэрэг зөрчилтэй иргэн 266 буюу 20 орчим хувийг эзэлж байна. Түүнчлэн Цэргийн штабын хамт олон иргэдийн лавлагааг гаргуулан үнэмлэхэд тэмдэглэл хийх, зөрчил гаргасан иргэдэд "Зөрчлийн тухай хууль"-ийн дагуу хариуцлага хүлээлгэн ажиллаж байна.

Дэд хурандаа Ж.БАТТУЛГА

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол Нийт: 219,287,475
Эдгэрсэн Нийт: 196,076,745
Нас барсан Нийт: 4,545,523

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 20	🌧️ 1

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 31	🌧️ 22

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	2.848.0	2.851.0
EUR 🇪🇺	3.375.0	3.386.0
CNY 🇨🇳	441.0	442.5
RUB 🇷🇺	38.50	39.60
JPY 🇯🇵	25.68	26.12
KRW 🇰🇷	2.42	2.51

ЗУРХАЙ

2021.9.3 БААСАН ГАРАГ
/БИЛГИЙН ТООЛЛЫН 27/

ӨГЛӨГТ ОХИН ОДТОЙ,
ХАРАГЧИН ҮХЭР ӨДӨР

Үс засуулбал:

Өлзийтэй сайн

Наран ургах, шингэх:

06.13-19.30

Барилдлага:

Үл тохирох

Шүтэн барилдлага:

Авахуй

Суудал:

Мод

Тухайн өдөр тахиа, могой жилтнээ аливаа үйлийг хийхэд зэрэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй.

Эл өдөр найз нөхдийг түшиж элдэв үйлийг түргэн бүтээх, бүтээл туурвил эхлэх, бизнес эхлэх, цар ихтэй үйлийг эхлэх, бясалгал хийх, доодсыг асран өглөг, хандив өргөх, угаал үйлдэх, мал арилжих, гэр бүрэхэд сайн. Улааны үйлд муу.

Өдрийн сайн цаг нь бар, туулай, могой, бич, нохой, гахай болой. Хол газар яваар одогсод баруун хойш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал жаргал үргэлжид ирэх сайн.



ЭЦЭГ ЭХ, АСРАН ХАМГААЛАГЧИД АА!



ШИНЖ ТЭМДЭГ ИЛЭРВЭЛ ЦЭЦЭРЛЭГ СУРГУУЛЬД НЬ ЯВУУЛАХҮЙ
ЭМЧИД ЯАРАЛТАЙ ХАНДААРЫ!

#riskcommunication team

АХМАД ТӨГСӨГЧДИЙН ЭНГЭРИЙГ МЯЛААВ



Тбилисийн Улаан тугийн одонт Бакугийн 26 комиссарын нэрэмжит Артиллерийн тусгай дунд сургууль гэж 1864 онд Оросын I Петр хааны санаачилгаар явган цэргийн юнкерүүд буюу офицеруудыг бэлтгэх зорилгоор анх байгуулагджээ. Хаант Оросын үеэс эхлэн Зөвлөлт засгийн он жилүүдэд олон мянган офицеруудыг сурган төгсгөж, тэд эх орныхоо аюулгүй байдлыг сахин хамгаалах үйл хэрэгт нэр төртэй хүчин зүтгэсэн байдаг. Тус сургуульд 1956 онд анхны монгол сонсогчид суралцахаар очсон цагаас хойш 1969 он хүртэл нийтдээ 30 гаруй хүн "Дайны бурхан" их буучны мэргэжил эзэмшин төгсжээ. Цагийн эрхээр тэднээс өдгөө 10-аадхан хүн амьд сэрүүн үлдэж, усан үзсийн дарсаараа дэлхийд алдартай Гүрж нутаг, уулын зочломтгой зон олон, сонсогч ахуй насаа дурсаж сууна. 2021 оны хичээлийн шинэ жил эхэлсэн Эрдмийн өдөр "Монголын тбилисчүүд"-ийн хувьд нэгэн тэмдэглэлт үйл явдал

тохиов. ОХУ-д ажиллаж, амьдардаг Тбилисийн артиллерийн тусгай дунд сургуулийн төгсөгчдийн холбооноос "Тбилисийн артиллерийн сургуулийн ахмад дайчин" дурсгалын медалиар монголын төгсөгчдөө шагнасан шагналыг эздэд нь гардуулах ёслол Батлан хамгаалахын Аж үйлдвэрийн нэгдлийн байранд боллоо. Сургуулийнхаа хүндэт шагналыг гардаж авахаар ирсэн ахмад их буучдын дунд бурхны оронд одсон төгсөгчдийн гэр бүл, хүүхдүүд байцаж энэхүү баярыг хуваалцсан юм. Шагналыг Монголын Артиллерийн цэргийн холбооны Ерөнхийлөгч, бэлтгэл хошууч генерал Б.Баярмагнай, Батлан хамгаалахын Аж үйлдвэрийн нэгдлийн Ерөнхий захирал, бэлтгэл бригадын генерал Н.Энхбаяр нар Тбилисийн сургуулийн ахмад төгсөгчид, ар гэрийнхэнд гардуулан өгөв. Анхны төгсөгчдийн нэг чөлөөнд байгаа хурандаа Ч.Дондов "Багш нар бидэнд сурлага, дэг журмаараа монгол сонсогчид бусдаас

ялгарч байх ёстой. Та нарт тавигдах шаардлага орос сонсогч нартай адилхан байх болно гэж хэлдэг байлаа" хэмээн дурсав. Мөн хамгийн сүүлийн буюу 1969 оны төгсөгч бэлтгэл хурандаа Ш.Нэргүй "Артиллерийн цэргийн эрдмийг бидэнд маш сайн эзэмшүүлсэн. Дараа нь академиас ч ийм суурь мэдлэгийг олж аваагүй шүү. Иймээс төрөлх сургуульдаа насан туршдаа талархаж явдаг" гэсэн юм. 2017 онд тус сургуулийн үүх түүхийг өгүүлсэн Вячеслав Лушновын бүтээл "Юнкера Святого Георгия" ном ОХУ-д хэвлэгдэн гарчээ. Монгол төгсөгчдийн дурсамж, багш нартайгаа хамт авуулсан сонсогч насны гэрэл зургууд уг номд бүлэг болон нийтлэгдсэн аж. Уг номыг орос төгсөгч нар монгол андууддаа илгээснийг мөн л гурван жилийн өмнө хүндэтгэлтэй гардаж авч байснаа ахмад төгсөгчид энэ үеэр бахархан дурсав. **Ахлах ахлагч Г.БАТ-ЭРДЭНЭ**

"ГҮЙЖ ЯВАА ХҮҮ" МОНГОЛ ЦЭРГИЙН МУЗЕЙД...



Зэвсэгт хүчний түүхт 100 жилийн ойн арга хэмжээ 2021 он дуустал олон хэлбэр, агуулгаар үргэлжилж байна. Энэ арга хэмжээнүүдийн нэг болох "Зэвсэгт хүчин-100 жил" үзэсгэлэнг Монгол цэргийн музейгээс дэглэн үзэгч олны хүртээл болгож байгаа. Тус үзэсгэлэнд өнгөрөгч 7 дугаар сард Ховд-Улаанбаатар-Дорнод гэсэн маршрутаар 46 хоногт 2127 км замыг гүйж туулсан Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн хөгжмийн салааны хөгжимчин, ахлах ахлагч Э.Даваажамцын өмссөн цэргийн дүрэмт хувцас, Төрийн далбаа зэрэг эд өлгийн зүйлсийг Монгол цэргийн музейн сан хөмрөгт дурсгал болгон хадгалуулсан. Үүнийг түүхэн үйл явдлын гэрч болсон бусад үзмэрүүдийн хамт "Зэвсэгт хүчин-100 жил" үзэсгэлэнд нэмэлтээр дэглэлт хийн баяжуулж үзүүлэнгийнхээ хүрээг тэлжээ. Ийнхүү "гүйж яваа хүү" Монгол цэргийн музейн хойморт зарларлаа.

ФОТО АГШИН



Гэрэл зургийг ахлах ахлагч Г.Бат-Эрдэнэ

БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙДЫН НЭРЭМЖИТ 2021 ОНЫ "ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИ, ИННОВАЦЫН ШИЛДЭГ БҮТЭЭЛ" ШАЛГАРУУЛАХ УРАЛДААНЫГ ЗАРЛАЖ БАЙНА

Улс орныг батлан хамгаалах үйл ажиллагаанд шинжлэх ухаан, технологи, инновацын үр дүнг нэвтрүүлэх, түүний хөгжлийг дэмжих, эрдэм шинжилгээний ажилтнуудын идэвх, санаачилгыг өрнүүлэх, оюуны чадавх, мэдлэгийг арвижуулах, шилдэг бүтээлүүдийг сурталчлах зорилгоор Монгол Улсын Батлан хамгаалахын сайдын нэрэмжит "Шинжлэх ухаан, технологи, инновацын шилдэг бүтээл" шалгаруулах уралдааныг зарлаж байна.

Нэг. Шалгаруулах бүтээл

Монгол Улсын Батлан хамгаалахын сайдын нэрэмжит шинжлэх ухаан, технологи, инновацын шилдэг бүтээлийг:

- "Аюулгүй байдал, батлан хамгаалах судлал", "Зэвсэглэл, техник технологи" гэсэн хоёр чиглэлээр тэргүүн, дэд байр тус бүр нэг бүтээл;
- 35 хүртэлх насны залуу судлаачийн бүтээл;
- Шилдэг инновацын бүтээл;
- Шинэ бүтээл, оновчтой саналын бүтээл гэсэн нийт 7 төрлөөр бүтээлийг шалгаруулна.

Хоёр. Шагналын сан

- Шагналын сангийн хэмжээ нийт 13,0 сая төгрөг;
- Тэргүүн байрт шалгарсан бүтээл тус бүрд "Шинжлэх ухаан, технологийн шилдэг бүтээлийн тэргүүн байр"-ын өргөмжлөл, 3,000,000.00 (гурван сая) төгрөг;
- Дэд байрт шалгарсан бүтээл тус бүрд "Шинжлэх ухаан, технологийн шилдэг бүтээлийн дэд байр"-ын өргөмжлөл, 2,000,000.00 (хоёр сая) төгрөг;
- 35 хүртэлх насны залуу судлаачийн нэг бүтээлд өргөмжлөл, 1,500,000.00 (нэг сая таван зуун мянга) төгрөг;
- Шилдэг инновацын нэг бүтээлд өргөмжлөл, 1,000,000.00 (нэг сая) төгрөг;
- Шинэ бүтээл, оновчтой саналын нэг бүтээлд өргөмжлөл, 500,000.00 (таван зуу мянга) төгрөгийн мөнгөн урамшууллыг тус тус олгоно.

Гурав. Бүтээлд тавигдах шаардлага

Эрдэмтэн, судлаачдын эрдэм шинжилгээ, судалгаа, туршилт, зохион бүтээх ажлын үр дүнд бий болсон улс орноо батлан хамгаалах эрх ашиг, цэргийн шинэчлэлд дорвитой хувь нэмэр оруулахуйц аюулгүй байдал, батлан хамгаалахын болон цэргийн шинжлэх ухааны онол, урлаг, арга зүйн ном, нэг сэдэвт бүтээл (монограф) болон зэвсэглэл, техник технологийн чиглэлээр зохион бүтээгдсэн ажил, эрдэм шинжилгээ, судалгааны ажилд зориулан гаргасан бүтээлийг шалгаруулалтад хүлээж авна.

Дөрөв. Шилдэг бүтээлийн шалгаруулах уралдаанд ирүүлэх материалын бүрдүүлэлт

² "Патентын тухай" хууль. 3.1.1. "Шинэ бүтээл" гэж байгалийн хуульд тулгуурлан сэдэж, үндэслэлийг нь тодорхойлсон, үйлдвэрлэх арга ажиллагаа болон бүтээгдэхүүнд хамаарах, шинэ бүтээлийн түвшин агуулсан шинэ шийдлийг;

³ "Патентын тухай" хууль. 4.3. "Шинэ бүтээлийн түвшин агуулсан" гэдгээт шинэ бүтээл нь холбогдох мэргэжлийн хүний хувьд ялгаарх давуу шинж чанартайг шинжээч тогтоосон байдлыг ойлгоно.

4.1. Шалгаруулалтад оролцуулах бүтээлийн хэвлэн нийтлэгдсэн эх, зохион бүтээгдсэн бие анги;

4.2. Зэвсэглэл, техник технологийн бүтээлд техникийн зураг, технологийн карт, технологийг ашигласны эдийн

Уралдаанд эрдэм шинжилгээний байгууллага, аж ахуйн нэгж, судлаачид, эрдэмтдийн хамтлаг, хувь хүмүүс шинжлэх ухааны бүтээлээ дэвшүүлж болно.

Уралдаанд судлаачдын сүүлийн 2 жилийн дотор туурвисан бүтээлийг дэвшүүлнэ. Уралдаанд ирүүлж буй бүтээл нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- "Патентын тухай" хуулийн 3.1.1 дэх заалт, мөн хуулийн 4.3 дахь хэсэгт заасан шинэ бүтээлийн түвшнийг агуулсан байх;
- Бүтээлийн шинжлэх ухаан, технологид оруулж буй хувь нэмэр, ач холбогдолтой байх;
- Тухайн бүтээлийг хэвлэн нийтлүүлсэн болон үйлдвэрлэлд нэвтрүүлсэн байдал, гарсан үр дүнтэй байх;
- Шинэ санаа, тэргүүний технологийг түгээн дэлгэрүүлэх инновацын чиг хандлагатай байх;
- Шинээр олдсон түүх, соёлын ховор нандин дурсгал, эд өлгийн зүйлс, ховор олдворын тухай эрдэм шинжилгээний ажлын үр дүнгээр хийсэн бүтээл, тайлан байж болно.

Хамтын бүтээлийг нэр дэвшүүлэхдээ зохиогчийн хамтлаг нь 5 хүнээс хэтрэхгүй байна. Хэрэв зохиогчийн хамтлаг 5 хүнээс илүү байх тохиолдолд уг бүтээлийг бий болгоход гишүүн бүрийн оруулсан бодит хувь нэмэр, оролцоог дэвшүүлж буй байгууллагын Эрдмийн зөвлөл эсхүл хамтын олны хурлын нууц санал хураалт явуулж, олонхын санал авсан дарааллаар зохиогчдыг нэр дэвшүүлнэ. Хамтын бүтээлийн зохиогчдын бүрэлдэхүүн, оролцоог нэр дэвшигч бүхэн хүлээн зөвшөөрч гарын үсэг зурсан байна. Бүтээлийг бий болгоход захиргааны буюу зохион байгуулалтын ажил эрхэлж байсан хүнийг зохиогчийн хамтлагийн бүрэлдэхүүнд оруулахгүй.

Эрдмийн зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл, орчуулсан ном, сурах бичиг, гарын авлага, улсын захиалгат шинжлэх ухаан, технологийн төсөл, гадаадын хамтарсан төсөл, захиалгат даалгаварт судалгааны ажлын үр дүнгээр бүтээгдсэн бүтээлийг шалгаруулалтад хүлээн авахгүй.

Дөрөв. Шилдэг бүтээлийн шалгаруулах уралдаанд ирүүлэх материалын бүрдүүлэлт

² "Патентын тухай" хууль. 3.1.1. "Шинэ бүтээл" гэж байгалийн хуульд тулгуурлан сэдэж, үндэслэлийг нь тодорхойлсон, үйлдвэрлэх арга ажиллагаа болон бүтээгдэхүүнд хамаарах, шинэ бүтээлийн түвшин агуулсан шинэ шийдлийг;

³ "Патентын тухай" хууль. 4.3. "Шинэ бүтээлийн түвшин агуулсан" гэдгээт шинэ бүтээл нь холбогдох мэргэжлийн хүний хувьд ялгаарх давуу шинж чанартайг шинжээч тогтоосон байдлыг ойлгоно.

4.1. Шалгаруулалтад оролцуулах бүтээлийн хэвлэн нийтлэгдсэн эх, зохион бүтээгдсэн бие анги;

4.2. Зэвсэглэл, техник технологийн бүтээлд техникийн зураг, технологийн карт, технологийг ашигласны эдийн

засгийн үр ашгийн тооцоог хавсаргасан байна. Үүнд:

- технологийн үнэ (борлуулалтын өртөг);
- үйлдвэрлэлийн зардал;
- бүтээгдэхүүний өөрийн өртөг;
- үйлдвэрлэлийн орлого;
- үйлдвэрлэлийн цэвэр ашиг;
- өртгөө нөхөх хугацаа;
- тухайн технологиор үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний чанарын түвшин, стандарт, зах зээл, аюулгүй байдал, технологийн боловсролгүй байдал (ашиглагдаж буй технологиудын дотор шинэ ба шинэчлэгдсэн дэвшилтэт технологийн эзлэх хувийн жин);
- материалын ашиглалт (хаягдлын үзүүлэлт);
- тухайн технологийн онцлогтой холбогдох бусад хүчин зүйл, үзүүлэлт зэрэг болно.

4.3. Бүтээлийн танилцуулга (Үүнд: зохиогч /хамтран зохиогч/-ийн нэр, аюулгүй байдал, батлан хамгаалах судлал, цэргийн шинжлэх ухааны онол, арга зүй болон зэвсэглэл, техник, технологийн шийдэлд оруулж буй хувь нэмэр, шинэлэг тал, үр ашиг, өгөөж, техник-эдийн засгийн үндэслэл болон үр ашгийн тооцоо);

4.4. Уг бүтээлийг шүүн хэлэлцээд Батлан хамгаалахын сайдын нэрэмжит оны шилдэг бүтээлийн шалгаруулалтад дэвшүүлж буй Зэвсэгт хүчний Жанжин штабын Шинжлэх ухаан, технологийн салбар зөвлөл, сургууль, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагын албан бичиг, Эрдмийн зөвлөл (Сургалт-арга зүйн зөвлөл)-ийн протокол;

4.5. Уг бүтээлийн цэргийн хэрэг, үйлдвэрлэлд туршиж, нэвтрүүлсэн тухай байгууллагын тодорхойлолт;

4.6. Уг бүтээлд тухайн мэргэжлийн 2-оос доошгүй эрдэмтний дүгнэлт, шүүмж байна;

4.7. Шалгаруулалтад ирүүлж буй бүтээлийн оюуны өмчийн гэрчилгээ, патент, ашигтай загварын гэрчилгээг хавсаргана;

4.8. Нууцын зэрэгтэй бүтээлийг нэр дэвшүүлсэн тохиолдолд бүрдүүлсэн материалд нууцын тэмдэг дарж, шаардлагыг хангуулсан байна.

Шалгаруулалтад ирүүлэх материалын бүрдэлт дутуу, хугацаа хэтэрсэн тохиолдолд бүтээлийг хүлээн авахгүй. Өмнө нь төр засгийн болон үндэсний хэмжээний албан ёсны шагнал, шалгаруулалтад шалгарч байсан бүтээлийг хүлээн авч, давхардуулан шалгаруулахгүй.

Тав. Нэр дэвшигч буй бүтээлийг хүлээн авах, шалгаруулах Шалгаруулалтад нэр дэвшүүлж буй бүтээл нь тавигдах шаардлага, зохих бүрдүүлэлтийг хангасан байх ба түүнийг бүрдүүлсэн материал, баримт бичгийн хамт зохиогч эсвэл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс Батлан хамгаалах яамны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн эрдэмтэн нарийн бичгийн дарга 2021 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 9.00 цагаас мөн сарын 15-ны өдрийн 18.00 цагийн дотор хүлээн авч, яамны Шинжлэх ухаан, технологийн зөвлөл шалгаруулж, Монгол Улсын Шинжлэх ухааны ажилтны өдрөөр шагналыг гардуулна.

Холбоо барих утас: 96887018, 151-263202

Цахим шуудангийн хаяг: sodnomtsog.d@mod.gov.mn

БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМНЫ ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ЗӨВЛӨЛ